**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/155НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас: 70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn<br>Аудитор: Т.Бат-Эрдэнэ<br>Утас:70432545 Цахим хаяг: Bat-erdenet@audit.gov.mn |


*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

**Агуулга**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** .......... 2
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** .......... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .......... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......... 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .......... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 8
**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** .......... 9
3.1. Төлбөрийн акт .......... 9
3.2. Зөвлөмж .......... 10
**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** .......... 11
**5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ** .......... 11

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 183

танай__________-ны №__________-т

МӨНХХАЙРХАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.БАДАМХАНД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг**

Сургуулийн бүсийг утасгүй интернетээр хангах, цахим анги байгуулсантай холбоотой үүссэн өр төлбөрийг 26,630.9 мянган төгрөгөөр бууруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус сургууль нь тайлант онд 90,152.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 27,878.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил нийт 118,031.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актлалсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

2025-2026 оны хичээлийн жилд байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ V-р түвшинд үнэлэгдсэн. Багш нарын мэргэжлийн гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр нийт

8426050437

13 багш үнэлэгдсэн ба II түвшинд 3, III түвшинд 4, IV түвшинд 6 багш үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*(төгрөгөөр)*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **174,017,714.46** | **174,523,692.61** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 56,521,576.00 | 50,429,576.41 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 56,521,576.00 | 50,429,576.41 |
| **3121** | **Төгрөг** | 56,521,576.00 | 50,429,576.41 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 56,521,576.00 | 50,429,576.41 |
| **33** | **АВЛАГА** | - | 10,398,555.82 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 10,398,555.82 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 117,496,138.46 | 113,695,560.38 |
| **351** | **Түүхий эд материал** | 4,753,830.46 | 4,798,830.46 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,669,570.46 | 4,669,570.46 |
| 35130 | Эм боох материал | 84,260.00 | 129,260.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 11,070,929.00 | 13,696,419.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 101,671,379.00 | 95,200,310.92 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 570,000.00 | 2,457,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,750,855.00 | 8,724,855.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | - |
| 35460 | Хүнсний материал | 46,465,700.00 | 32,844,040.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 37,884,824.00 | 51,173,915.92 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,760,347,147.62** | **1,629,342,733.95** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,760,347,147.62 | 1,629,342,733.95 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,709,825,147.62 | 1,578,920,733.95 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,595,107,015.00 | 1,595,107,015.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (248,540,866.91) | (307,101,983.51) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 396,914,778.91 | 317,881,481.91 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (175,038,526.81) | (148,474,665.59) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 180,683,741.60 | 160,401,551.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (53,637,070.21) | (53,228,741.50) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 40,234,345.00 | 40,234,345.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (40,148,913.96) | (40,148,913.96) |
| 39217 | Ном | 14,250,645.00 | 14,250,645.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 50,522,000.00 | 50,422,000.00 |
| 39301 | Програм хангамж | 457,000.00 | 457,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (357,000.00) | (457,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 50,422,000.00 | 50,422,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,934,364,862.08** | **1,803,866,426.56** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **93,042,509.15** | **78,062,909.15** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 93,042,509.15 | 78,062,909.15 |
| **413** | **Өглөг** | 93,042,509.15 | 78,062,909.15 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,392,895.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 91,649,614.15 | 78,062,909.15 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 91,649,614.15 | 77,990,834.15 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 72,075.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,841,322,352.93** | **1,725,803,517.41** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,841,322,352.93 | 1,725,803,517.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 782,392,204.00 | 782,392,204.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 782,392,204.00 | 782,392,204.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 178,507,283.93 | 62,988,448.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (93,919,192.59) | 178,507,283.93 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 272,426,476.52 | (115,518,835.52) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 880,422,865.00 | 880,422,865.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,934,364,862.08** | **1,803,866,426.56** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*(төгрөгөөр)*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,368,474,847.10** | **2,246,774,191.92** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **465,483,547.10** | **20,084,291.92** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 465,483,547.10 | 20,084,291.92 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 465,483,547.10 | 20,084,291.92 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,445,000.00 | 952,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,400,000.00 | 6,059,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 459,638,547.10 | 13,072,591.92 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,902,991,300.00** | **2,226,689,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,657,868,800.00 | 2,000,337,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,657,868,800.00 | 2,000,337,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 22,701,600.00 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,131,600.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 570,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 222,420,900.00 | 226,352,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 222,420,900.00 | 226,352,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,065,648,386.21** | **2,362,293,027.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,065,648,386.21** | **2,362,293,027.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,013,347,951.84 | 2,300,884,107.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,336,212,774.92 | 1,590,673,189.23 |
| 210101 | Үндсэн цалин | 970,809,467.39 | 1,245,525,387.44 |
| 210102 | Нэмэгдэл | 296,143,472.14 | 312,929,422.16 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 5,334,192.34 |
| 210104 | Урамшуулал | 69,259,835.39 | 26,884,187.29 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 165,823,292.00 | 197,543,764.54 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 113,900,399.00 | 135,698,905.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,400,075.00 | 15,880,179.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,010,497.00 | 8,407,869.56 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,307,264.00 | 7,484,533.28 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,205,057.00 | 30,072,277.18 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 215,557,655.63 | 219,209,901.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,339,011.63 | 14,351,257.16 |
| 210302 | Түлш, халаалт | 203,418,644.00 | 203,418,644.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 800,000.00 | 1,440,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 37,451,148.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 37,451,148.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 45,227,380.00 | 64,972,605.00 |
| 210502 | Хоол, хүнс | 45,227,380.00 | 64,972,605.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,688,965.00 | 156,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,688,965.00 | 156,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 26,632,684.23 | 20,951,136.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,023,400.00 | 2,183,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14,609,284.23 | 18,767,236.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 178,754,052.06 | 207,377,511.67 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 47,835,430.00 | 47,265,119.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,477,830.00 | 10,392,279.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 118,440,792.06 | 149,720,113.67 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 52,300,434.37 | 61,408,919.84 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 50,947,055.00 | 58,506,321.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 34,812,950.00 | 58,506,321.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,134,105.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,353,379.37 | 2,902,598.84 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,353,379.37 | 2,902,598.84 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **302,826,460.89** | **(115,518,835.52)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 30,399,984.37 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 30,399,984.37 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (30,399,984.37) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **272,426,476.52** | **(115,518,835.52)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*(төгрөгөөр)*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл** | 782,392,204.00 | 880,422,865.00 | 178,507,283.93 | 1,841,322,352.93 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **782,392,204.00** | **880,422,865.00** | **(93,919,192.59)** | **1,568,895,876.41** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 272,426,476.52 | 272,426,476.52 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **782,392,204.00** | **880,422,865.00** | **178,507,283.93** | **1,841,322,352.93** |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл** | **782,392,204.00** | **880,422,865.00** | **178,507,283.93** | **1,841,322,352.93** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **782,392,204.00** | **880,422,865.00** | **178,507,283.93** | **1,841,322,352.93** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (115,518,835.52) | (115,518,835.52) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **782,392,204.00** | **880,422,865.00** | **62,988,448.41** | **1,725,803,517.41** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*(Төгрөгөөр)*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,908,836,300.00** | **2,233,701,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,845,000.00** | **7,011,700.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **5,845,000.00** | **7,011,700.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **5,845,000.00** | **7,011,700.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,445,000.00 | 952,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,400,000.00 | 6,059,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,902,991,300.00** | **2,226,689,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,657,868,800.00** | **2,000,337,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,657,868,800.00 | 2,000,337,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **22,701,600.00** | **-** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,131,600.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 570,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **222,420,900.00** | **226,352,000.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 222,420,900.00 | 226,352,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,973,733,670.08** | **2,239,793,599.59** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,973,733,670.08** | **2,239,793,599.59** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,912,067,390.71** | **2,177,738,100.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,332,837,830.46** | **1,599,438,804.59** |
| 210101 | Үндсэн цалин | 811,081,951.07 | 814,701,827.57 |
| 210102 | Нэмэгдэл | 428,889,607.65 | 671,166,753.30 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 24,702,400.00 |
| 210104 | Урамшуулал | 92,866,271.74 | 88,867,823.72 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **167,310,669.54** | **200,500,600.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 113,344,500.00 | 136,340,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,667,660.00 | 16,039,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,675,500.00 | 8,020,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,974,409.54 | 8,020,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,648,600.00 | 32,080,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **215,557,655.63** | **219,209,901.16** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,339,011.63 | 14,351,257.16 |
| 210302 | Түлш, халаалт | 203,418,644.00 | 203,418,644.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 800,000.00 | 1,440,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **65,090,230.00** | **51,350,945.00** |
| 210502 | Хоол, хүнс | 65,090,230.00 | 51,350,945.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,509,865.00** | **4,239,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 5,509,865.00 | 4,239,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **36,512,170.08** | **24,832,700.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,023,400.00 | 2,183,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 24,488,770.08 | 22,648,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 89,248,970.00 | 78,165,650.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 78,217,370.00 | 69,725,150.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,031,600.00 | 8,440,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,666,279.37** | **62,055,498.84** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 60,312,900.00 | 59,152,900.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 42,679,900.00 | 59,152,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,633,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,353,379.37** | **2,902,598.84** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,353,379.37 | 2,902,598.84 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(64,897,370.08)** | **(6,091,999.59)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (64,897,370.08) | (6,091,999.59) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **121,418,946.08** | **56,521,576.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **56,521,576.00** | **50,429,576.41** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*(Төгрөгөөр)*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,315,014,500.00** | **2,236,891,000.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,315,014,500.00** | **2,236,891,000.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,253,458,000.00** | **2,177,738,100.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,637,129,500.00** | **1,599,438,804.59** |
| 210101 | Үндсэн цалин | 909,432,000.00 | 839,201,827.57 |
| 210102 | Нэмэгдэл | 658,338,100.00 | 646,666,753.30 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 24,702,400.00 |
| 210104 | Урамшуулал | 69,359,400.00 | 88,867,823.72 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **205,084,000.00** | **200,500,600.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 139,457,100.00 | 136,340,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,406,600.00 | 16,039,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,203,400.00 | 8,020,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,203,400.00 | 8,020,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,813,500.00 | 32,080,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **221,252,000.00** | **219,209,901.16** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,343,900.00 | 14,351,257.16 |
| 210302 | Түлш, халаалт | 203,468,100.00 | 203,418,644.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,440,000.00 | 1,440,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **77,885,400.00** | **51,350,945.00** |
| 210502 | Хоол, хүнс | 77,885,400.00 | 51,350,945.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,100,000.00** | **4,239,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 5,100,000.00 | 4,239,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **24,832,700.00** | **24,832,700.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,183,900.00 | 2,183,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 22,648,800.00 | 22,648,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **82,174,400.00** | **78,165,650.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 73,687,200.00 | 69,725,150.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,487,200.00 | 8,440,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **61,556,500.00** | **59,152,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **61,556,500.00** | **59,152,900.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 61,556,500.00 | 59,152,900.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,315,014,500.00** | **2,230,799,001.16** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,023,414,200.00** | **2,000,337,900.00** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,023,414,200.00 | 2,000,337,900.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **226,352,000.00** | **223,449,401.16** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 226,352,000.00 | 223,449,401.16 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **65,248,300.00** | **7,011,700.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,752,700.00 | 952,700.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,059,000.00 | 6,059,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **56,521,576.00** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **50,429,576.41** |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,330.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

Залруулагдаагүй нийт 6,330.0 мянган төгрөгийн 4 зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 6,330.0 мянган төгрөгийн 4 зөрчил илэрч 2 төлбөрийн акт тогтоолоо.

### 3.1. Төлбөрийн акт

***3.1.1 Илрүүлэлт:*** Байгууллагын удирдлага нь нягтлан бодогч, нярав нарт ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон болович тус урамшуулалтай давхардуулан сургуулийн захирлын 2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн Б/48 тоот тушаалаар санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 2,091,240 (Хоёр сая ерэн нэгэн мянга хоёр зуун дөчин ) төгрөгийн урамшуулал илүү олгоод буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төлбөрийн акт тогтоов.

***3.1.2 Илрүүлэлт:*** Тус байгууллага нь Мобиком болон Юнител ХХК-тай антены түрээсийн гэрээг сарын 200.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан. Тайлант хугацаанд түрээсийн орлого 4,064.0 мянган төгрөгийн орлого олж 40% болох 1,625.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан

баталгаажуулах”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2-д “Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 хувиар тогтоосугай” заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төлбөрийн акт тогтоов.

### 3.2. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.2.1 Үдийн хоолтой холбоотой асуудал

Илрүүлэлт: Үдийн хоолны бараа материалын нөөцийн удирдлага, хадгалалт, мэдээллийн бүртгэл хангалтгүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 11.1.6-т "хоолны норматив зардлыг өөр зориулалтаар ашиглах”, 3.1.2-т "хоолны зардлын норматив" гэж нэг хүүхдэд ногдох хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний зардлыг” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтын хяналтын тогтолцоог сайжруулж, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэн тогтмол хөтлөх шаардлагатай

#### 3.2.2 Ирцтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн ирцийг ангилаагүй. Цахим бүртгэлийн систем нь багш нар ирцийн мэдээгээс 389 хүүхдээр зөрүүтэй зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” заалтууд болон БШУЯ-ны 2020 оны 3/1557 дугаар албан бичиг "Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем"-ийн www.esis.edu.mn цахим системийг ашиглан бүртгэх тухай зөвлөмжүүдтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Дотуур байранд амьдрах хүүхдийн ирцийг дунд болох ахлах ангиар ангилж гаргах, цахим бүртгэлийн системд ирц бүрэн шивж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*(мянган төгрөгөөр)*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | - | - | - | - | - | - | - | - | - | - |

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*(мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Мөнххайрхан сумын сургууль | Нягтланд 1,223,815 төгрөг, няравт 867,425 төгрөгийн балансын урамшуулал олгосон. | 1 | 2,338.5 | 1 | 2,338.5 | | | | | | |
| | Үүрэн холбооны антены түрээсийн орлогын 40%-ийг төвлөрүүлээгүй. | 1 | 1,625.6 | 1 | 1,625.6 | | | | | | |
| | Үдийн хоолны зардлыг нормоос хэтрүүлсэн | 1 | 2,613.2 | | | | | 1 | 2,613.2 | | |
| | Дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн ирцийг ангилаагүй. Цахим бүртгэлийн систем нь багш нар ирцийн мэдээгээс 389 хүүхдээр зөрүүтэй байна. | 1 | - | | | | | 1 | - | | |
| **Нийт дүн** | | **4** | **6,330.0** | **2** | **3,716.8** | **-** | **-** | **2** | **2,613.2** | **-** | **-** |

## 5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |